

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ОРОН НУТАГТ ТӨЛӨӨЛӨН
2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ХҮРЭЭНД БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРТ ХАМТРАН АЖИЛЛАХ 22-10 ТООТ ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТЭД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2022.11.28

Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хагас жилээр явцын хяналт-шинжилгээг хийж, зөвлөн туслах арга хэмжээг зохион байгуулж удаашралтай байгаа заалтуудыг эрчимжүүлэх талаар үүрэг чиглэл өгч ажилласан бөгөөд жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийлээ.

НЭГ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ЯВЦ, ДҮГНЭЛТ

Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт 2022 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2 -т заасан арга зүйгээр Байгаль орчин аялал жуулчлалын газраас ирүүлсэн тайланд үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт 2022 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 8 зорилтын хүрээнд 59 ажил тусган хэрэгжүүлэхээр ажилласан байна. Эхний хагас жилийн хэрэгжилтэд явцын хяналт шинжилгээ хийхэд 61.5 хувьтай байсан ба жилийн эцсийн байдлаар 97.28 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Гэрээний хэрэгжилтийг зорилт тус бүрээр харуулбал:

№	Зорилтын нэр	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь
1	Байгаль орчны багц хуулийн хэрэгжилтийг хангах	11	100
2	Ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангах талаар	3	100
3	Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийг хамгаалах	15	93.3
4	Усны нөөцийг зүй зохистой ашиглах, хамгаалах	4	100
5	Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах	4	100
6	Ойн нөөцийг хамгаалах, “Тэрбум мод” хөдөлгөөнийг өрнүүлж, зорилтын хэрэгжилтийг хангах	10	97
7	Аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар	9	96.6
8	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгүүлэх ажлууд	3	100
9	Дүн	59	97.28

ХОЁР. ТАЙЛАНГИЙН ХУГАЦААНД ДАРААХ АРГА ХЭМЖЭЭНҮҮД ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖСЭН БАЙНА.

Нийт 59 арга хэмжээ хэрэгжүүлэхээс 56 арга хэмжээ 100 хувь, 2 арга хэмжээ 70 хувь, 1 арга хэмжээ 0 хувь хэрэгжсэн байна.

Арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгийн хэмжээ

№	Зардлын ангилал	Төсөвлөсөн хөрөнгө /сая төгрөг/	Зарцуулсан хөрөнгө /сая төгрөг/
1	Улсын төсвийн хөрөнгө оруулалт	515.0	932.9
2	Орон нутгийн төсөв	238.0	352.2
3	Хувийн хэвшил	107.0	283.9
4	Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан	92.3	92.3
5	Нийт дүн	964.5	1.661.3

Гэрээгээр хүлээсэн арга хэмжээнүүдээс дараах арга хэмжээнүүд үр дүнтэй хэрэгжсэн гэж үзэв.

“Мод тарих, арчлах аргачлал, ногоон байгууламжийн төлөвлөлт хийх талаар 705, уул уурхай нөхөн сэргээлтийн талаар 24, Мандлын цэцэг тарих талаар 10, аялал жуулчлалын чиглэлээр 11, хог хаягдлын чиглэлээр 123, салбарын албан хаагчдад чадавхжуулах чиглэлээр 65, Биологийн олон янз байдлын чиглэлээр 24, Нийт 21 удаагийн сургалтад 851 иргэн хамрагдсан. Уг арга хэмжээнд Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 6.2 сая төгрөгийг зарцуулав.

Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийг 2 удаа зохион байгуулж, 1053 өрх, 147 аж ахуйн нэгж, байгууллагын 5690 иргэнийг хамруулан мэргэжил аргазүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Улсын төсвөөр 90.0, орон нутгийн төсвөөр 122.0, хувийн хэвшлийн хөрөнгөөр 116.3 сая төгрөг зарцуулж, Нийт 122884 мод, сөөгийг тарьснаас 75.8 хувьтай ургуулсан байна.

“БҮХ НИЙТЭЭР МОД ТАРИХ ӨДӨР”-ИЙГ УГТСАН “ДУНДГОВИО НОГООРУУЛЪЯ” ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДАА





3 ХОНОГ
ҮЛДЛЭЭ

**ХҮНСНИЙ НОГООНЫ
ҮР, ҮРСЭЛГЭЭ
БОР ДОО**

#Дундговно ногооруулъя
үзэсгэлэн худалдаа

2022 оны 05 дугаар сарын 13-14-ний
өдрүүдэд Мандал худалдааны төвийн гадна
талбайд

**НИЙТ 36 НЭР ТӨРЛИЙН
БАГАЖ ХЭРЭГСЭЛ
ТАНИЛЦУУЛАГДАНА**

#Дундговно ногооруулъя
үзэсгэлэн худалдаа

3 ХОНОГ
ҮЛДЛЭЭ



**“ДУНДГОВНО НОГООРУУЛЪЯ”
БҮХ НИЙТЭЭР МОД ТАРИХ ҮНДЭСНИЙ ӨДӨР**

ТЭРБҮМ МОД
ҮНДЭСНИЙ ХӨӨЛӨГӨӨНИ
2021-2030

ТҮМЭННЭН МОД



БОАЖЯамны хөрөнгө оруулалтаар Гурвансайхан сумын Их газрын чулуу, Өлзийт сумын Цагаан суварга байгалийн үзэсгэлэнт 2 газарт “Отоглох цэг”-ийг улсын төсвийн 197.2 сая төгрөг зарцуулж хийгдсэн.



Орон нутгийн хөрөнгө оруулалтаар аймгийн “Аялал жуулчлалын мэдээллийн төв”-ийг шинээр байгуулж гадаад, дотоодын жуулчдад мэдээлэл хүргэж, аюулгүй байдлыг ханган 230 хүнд үйлчилсэн. “Дундговьд төвлөрцгөө” аялал жуулчлалын анхдугаар форумыг 03 дугаар сарын 05, 06-ны өдрүүдэд орон нутгийн аялал жуулчлалын үйлчилгээний стандартыг сайжруулж, чадавхыг нэмэгдүүлэх илтгэл мэдээлэл, сургалтад 175 салбарын ажилтан хамрагдсан. Цагаан суварга байгалийн үзэсгэлэнт газрын “Сэтгэшгүй оддын чуулган”, Адаацаг сумын “Сүм хөх бүрд” байгалийн дурсгалт газарт “Адууны өв соёлын баяр” зэрэг эвент арга хэмжээнд 1420 гадаад, дотоодын жуулчид үзэж сонирхсон. Айхотел ХХК-тай хамтран ажиллах ДУЗДТГ-ОНХО/2022/35 гэрээ байгуулж Дундговь аялал жуулчлал, бизнес эрхлэгчдийн гар утасны платформыг хийлгэсэн зэрэг ажлуудад Орон нутгийн төсвөөс 134.5 сая төгрөг зарцуулсан нь үр дүнтэй хэрэгжсэн байна.





ГУРАВ. ДУТАГДАЛТАЙ БОЛОН ХЭРЭГЖЭЭГҮЙ АРГА ХЭМЖЭЭ

Цөлжилтийг сааруулах, газрын доройтлыг бууруулах зорилгоор хамгаалалтын ойн зурвас байгуулах арга хэмжээний хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас цөлжилтийг сааруулах, газрын доройтлыг бууруулах зорилгоор 3 сумын нутаг 20 га талбайд ойн зурвас байгуулах ажлын тендерийг 2 удаа зарлаж амжилтгүй болсон. Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсөв татагдсан тул худалдан авах ажиллагааг цуцалсан учраас үнэлгээнээс хасаж тооцсон


Аюултай хог хаягдлыг түр хадгалах агуулахын менежментийг хариуцах байгууллагыг сонгон шалгаруулахаар тусгай зөвшөөрөл бүхий 8 байгууллагад урилга хүргүүлсэн боловч хариуцагчаар ажиллах санал ирээгүй учраас тасарсан.

ДӨРӨВ. САНАЛ ДҮГНЭЛТ


Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг 97.28 хувьтай буюу "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж үнэлж, үнэлгээний саналыг хүргүүлж байна.

Байгаль орчин аялал жуулчлалын салбарт хэрэгжүүлэх арга хэмжээний шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшин нь төлөвлөлтийн шаардлага хангахгүй ирж байгаа учир үнэлгээ хийхэд хүндрэлтэй байлаа.

БАТАЛГААЖУУЛСАН:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА  Ц.МӨНХБАТ

ХЯНАСАН:
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Д.ДААРИЙМАА

ТАЙЛАН БИЧСЭН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН  Э.ОДОНЧИМЭГ

Дундговь аймгийн Засаг даргын 2022 оны
 дүгээр сарын өдрийн тоот
 албан бичгийн 1 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ОРОН НУТАГТ ТӨЛӨӨЛӨН 2022 ОНД
 ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ХҮРЭЭНД БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРТ
 ХАМТРАН АЖИЛЛАХ 22-10 ТООТ ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ

2022.11.28

Дундговь аймаг

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт					Хувь
		Зарцуулсан хөрөнгө	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин	
1. Байгаль орчны холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах заалтын хүрээнд:							
1	Байгаль орчны эсрэг гэмт хэрэг зөрчлийг бууруулах зорилгоор хамтарсан хяналт шалгалт зохион байгуулах	-	Хяналт шалгалт хийсэн тоогоор	39 удаагийн хяналт шалгалтыг 6 суманд зохион байгуулж, байгаль орчны эсрэг 3 гэмт хэргийн шинжтэй зөрчлийг таслан зогсоож, гарсан зөрчлийг 100% шийдвэрлүүлсэн.	Байгаль орчны салбар болон хууль хяналтын байгууллагуудын хамтарсан хяналт шалгалтын ажлыг 10-аас доошгүй удаа зохион байгуулснаар байгаль орчны эсрэг гэмт хэргийн зөрчил илрүүлэлтийг нэмэгдүүлсэн байна.	Амьтны хяналт шалгалт: Ангийн бүс нутаг бүхий 6 сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нар Хууль бус ангийн эсрэг хамтарсан хяналт шалгалт 34 удаа хийж нийт 42 тээврийн хэрэгсэл, 67 иргэнийг шалгахад хууль бус ангийн 1 тохиолдол бүртгэгдэж Экологийн цагдаагийн албанд шалгагдаж байна. Уул уурхайн хяналт шалгалт: Өлзийт, Дэрэн, Говь-Угтаал, сумдын уул уурхайн ашиглалт, хайгуулын үйл ажиллагаа явуулдаг ААНэгжүүдэд АЗДТГазар, МХГ, сумын ЗДТГазрын хамтарсан хяналт, шалгалтын ажлыг 6 удаа зохион байгуулан илэрсэн 3 зөрчлийг арилгуулан ажилласан.	100

						<p>Ногоон байгууламжийн хяналт: Сайнцагаан сумын мал бүхий иргэдийг малаа ногоон байгууламж руу оруулахгүй байх талаар мэдээлэл өгч 11 удаагийн хяналт шалгалтын ажлыг хийж нийт 8 иргэнд албан шаардлага хүргүүлж 6 иргэнд зөрчлийн тухай хуулийн дагуу торгуулийн арга хэмжээ авч ажилласан. Нийт 51 удаагийн хяналт, шалгалтыг хийж 10 удаагийн зөрчлийг илрүүлэн шийдвэрлэсэн. (Зураг хавсаргав)</p>	
2	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын албан хаагчдын нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх	11.5 БХНАХЗ	-Албан хаагчдыг 100% хамруулсан эсэх	-1 мэргэжилтэн дронтой болсон. -22 албан хаагчийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан.	-22 хүнийг нарийвчилсан эрүүл мэндийн үзлэгт хамруулсан байна. - Усны асуудал хариуцсан мэргэжилтний тоног төхөөрөмжийг сайжруулж, 1ш нөүтбүүк авсан байна.	Тус газар нь нийт 22 албан хаагчтайгаас 2 албан хаагч хүүхэд асрах чөлөөтэй, 20 албан хаагчийг аймгийн нэгдсэн эмнэлэгт үзлэг, шинжилгээнд 100% хамрагдсан. “ОД ЭС ЭС” ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулж Усны асуудал хариуцсан мэргэжилтнийг ажиллах нөхцөлийг сайжруулж 1ш нөүтбүүк авав. БХНСАХЗардалаас 11.5 сая төгрөгийг зарцуулав. (Зураг хавсаргав)	100
3	Байгаль орчны салбарын хууль тогтоомжоор сургалт зохион байгуулах	5.0 БХНСАХЗ	-Сургалт зохион байгуулсан тоо -Хамрагдсан иргэдийн тоо	2021 онд танхим болон цахимаар нийт 13 төрлийн сургалтыг 22 удаа зохион байгуулж 280 хүн хамруулсан.	20 удаагийн сургалт зохион байгуулж, байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, ЕБСургуулийн сурагчид, багш нар иргэдийг оролцуулан 500-аас доошгүй хүн хамруулна.	“Мод тарих, арчлах аргачлал, ногоон байгууламжийн төлөвлөлт хийх талаар 705, уул уурхай нөхөн сэргээлтийн талаар 24, Мандлын цэцэг тарих талаар 10, аялал жуулчлалын чиглэлээр 11, хог хаягдлын чиглэлээр 123, салбарын албан хаагчдад чадавхжуулах чиглэлээр 65, Биологийн олон янз байдлын чиглэлээр 24, Нийт 21 удаагийн сургалтад 851 иргэн хамрагдлаа.	100

						БХНСАХЗардалаас 6.2 сая төгрөгийг зарцуулав. (Зураг хавсаргав)	
4	“Байгаль орчны тэмдэглэлт өдрүүд”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх, олон нийтэд таниулах ажлыг зохион байгуулах	3.0 БХНСАХЗ	-Аймгийн хэмжээнд зохион байгуулсан арга хэмжээний тоо -Аймгийн хэмжээнд хамруулсан иргэдийн тоо	Дэлхийн ойн өдөр, Дэлхийн усны өдөр, Эх дэлхийн цаг, Бүх нийтээр мод тарих өдөр, Дэлхийн аялал жуулчлалын өдрүүдээр сургалт, гэрэл зургийн уралдаан, мод тарих, иргэдийг урамшуулах арга хэмжээнд нийт 3500 иргэн оролцов.	-8-аас доошгүй удаагийн арга хэмжээ зохион байгуулсан байна. -3000-аас дээш иргэн татан оролцуулна	“Эх дэлхийн цаг, Дэлхийн ойн өдөр, Дэлхийн усны өдөр, Дэлхийн биологийн олон янз байдлын өдөр, Дэлхийн аялал жуулчлалын өдөр, Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр” зэрэг байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажил, гэрэл зургийн уралдаан, мод тарих зэрэг нийт 11 арга хэмжээ зохион байгуулж, 5103 иргэнийг татан оролцууллаа. БХНСАХЗардалаас 3.0 сая төгрөгийг зарцуулав. (Зураг хавсаргав)	100
5	Мэдээллийн санд баяжилт хийх (eic.mn)	-	Мэдээлэл бүрэн оруулсан эсэх	Байгаль орчны нэгдсэн мэдээллийн www.eic.mn -д 6 төрлийн дэд санд мэдээлэл оруулсан.	6 төрлийн дэд санд мэдээллийг 100 хувь оруулсан байна.	Байгаль орчны нэгдсэн мэдээллийн www.eic.mn цахим сайтын 6 төрлийн дэд санд 15 сумын мэдээллийг 86 маягтын дагуу 100% оруулав. (Зураг хавсаргав)	100
6	Иргэн, аж ахуйн нэгж байгууллагад үзүүлэх үйлчилгээг цахимд шилжүүлэх	-	Цахимд шилжүүлсэн үйлчилгээний тоогоор	-	5 төрлийн үйлчилгээг и-монголиа цахим системд шилжүүлсэн байна.	“И-Монголиа” цахим системд “Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ”, “Ус ашиглуулах дүгнэлт гаргуулах хүсэлт хүлээн авах”, “Ус ашиглуулах гэрээ”, “Цооног өрөмдөх, худаг гаргах зөвшөөрөл”, “Ус ашиглах зөвшөөрөл олгох”, “Усны мэргэжлийн байгууллагын эрх олгох талаар дүгнэлт гаргах” гэсэн 6 үйлчилгээг нэвтрүүлж, 12 аж ахуйн нэгж, иргэнд цахимаар үйлчилгээ үзүүлээд байна. (Зураг хавсаргав)	100

7	Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийг дэмжих	-	Дэмжлэг үзүүлсэн тоо	-	2-оос доошгүй бүлэг, нөхөрлөлд дэмжлэг үзүүлсэн байна.	Гурвансайхан сумын Гурвансайхан агнуурын бүс нутгийн “Бид байна” нөхөрлөлд дуран, зургийн аппарат тус бүр 1, Өндөршил сумын Их баян уул агнуурын бүс нутгийн “Их баян” нөхөрлөлд өвлийн иж бүрэн хувцас 2, богино долгионы станц 3, дуран 1 ширхгийг өгч, нийт 2 нөхөрлөлд 3.2 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.	100
8	“Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 4.8 дахь заалтын хэрэгжилтийг хангах	-	-Газрын төлбөрийн орлогоос 15% -Усны төлбөрийн орлогоос 35% -Амьтны төлбөрийн орлогоос 50%	2021 онд Газрын төлбөрийн орлого 389.1 саяас 31.3 сая.төг, усны төлбөрийн орлого 251.1 саяас 21.0 сая.төг, амьтны төлбөрийн орлого 452.4 саяас 62.7 сая.төг тус тус зарцуулсан.	-Газрын төлбөрийн орлого 362.0 сая -Усны төлбөрийн орлого 100.0 сая -Амьтны төлбөрийн орлого 200.0 сая	2022 оны 10 дугаар сарын байдлаар Газрын төлбөрийн орлого 362.0 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 348.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй үүний 15 хувь буюу 54.3 сая төгрөгийг, усны төлбөрийн орлого 100.0 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 252.6 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа ба 35 хувь буюу 35.0 сая төгрөгийг, ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого 200.0 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 639.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа ба төлөвлөсөн орлогоос 72.42 хувь буюу 144.84 сая төгрөгийг зориулалтын дагуу тус тус зарцуулаад байна.	100
9	Сангийн сайд, Байгаль орчны сайдын хамтран баталсан 2006 оны 342/366 дугаар тушаал “Байгаль орчны хууль тогтоомжийн зөрчлийг илрүүлсэн буюу зөрчлийн талаар бодит мэдээлэл өгсөн	-	Урамшуулсан байгаль хамгаалагч, идэвхтэн байгаль хамгаалагчийн тоо, төлбөрийн орлогоос урамшуулсан хувь хэмжээ	Сангийн сайд, Байгаль орчны сайдын 2006 оны 342/366 дугаар тушаалын хэрэгжилт хангалтгүй.	Аливаа зөрчлийг илрүүлсэн буюу ноцтой зөрчлийн талаар цаг үеэ олсон бодитой үнэн зөв, тодорхой мэдээлэл ирүүлсэн иргэнд торгууль, нөхөн төлбөрийн орлогын 15%-тай тэнцэх мөнгөн урамшуулал олгосон байна.	Идэвхтэн байгаль хамгаалагчаар ажиллах журмын талаар танилцуулга, мэдээлэл хийж Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын 2022 оны Б/11 дугаар тушаалаар аялал жуулчлалын бүсэд шинээр 13 идэвхтэн байгаль хамгаалагчийг томилсон. Хяналт шалгалтаар зөрчил илрээгүй тул торгууль нөхөн төлбөрийн орлого ороогүй. (Зураг хавсаргав)	100

	иргэнд уламшуулал олгох журам"-ын хэрэгжилтийг хангах						
10	“Иргэн бүр байгаль хамгаалагч” уриан дор байгаль орчныг хамгаалах, зөв дадал зуршил бий болгох зорилгоор нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэх	-	Шинээр байгуулагдсан байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн тоо Шинээр нэмэгдсэн идэвхтэн байгаль хамгаалагчийн тоо	-	Байгаль орчныг хамгаалж, үр шимийг хүртэх зорилгоор иргэд сайн дурын үндсэн дээр нэгдэн нөхөрлөж үр дүн гарсан байна. Идэвхтэн байгаль хамгаалагчийг нэмэгдүүлсэн байна.	“Иргэн бүр байгаль хамгаалагч” уриан дор Байгаль хамгаалалд хүүхэд, залуусын оролцоо, эерэг хандлагыг нэмэгдүүлэх сургалтыг ЕБС-ийн 45 хүүхдэд зохион байгууллаа. Байгалийн үзэсгэлэнт газарт үйл ажиллагаа эрхэлдэг баазуудын удирдлага, менежер, харуулыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын 2022 оны Б/11 дугаар тушаалаар 13 идэвхтэн байгаль хамгаалагчийг томилсон. Дэрэн сумын “Дэн толгой” цагаан зээрийн агнуурын бүсэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх үүднээс “Дэн толгой” нөхөрлөлийг 8 хүний бүрэлдэхүүнтэй шинээр байгуулав.	100
2. Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх							
11	Үйлдвэрлэл үйлчилгээний /уул уурхай, аялал жуулчлал, ШТС./ бүс дэх нүхэн жорлонг үе шаттайгаар стандартын шаардлагад нийцүүлнэ	15.0 Хувийн хэвшил	Үйлдвэрлэл, үйлчилгээний бүс дэх сайжруулсан ариун цэврийн байгууламж, эко жорлонгийн эзлэх хувь	25 хувь	Үйлдвэрлэл үйлчилгээний бүс дэх сайжруулсан ариун цэврийн байгууламжийг 29.4%-д хүргэх	Их газрын чулуу байгалийн цогцолборт газар, Бага газрын чулуу улсын тусгай хамгаалалттай газарт тус бүр 1, Цагаан суварга орон нутгийн тусгай хамгаалалттай газар 2, уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжид 1, нийт 4 ширхэг эко ариун цэврийн байгууламж нэмэгдэж, Үйлдвэр үйлчилгээний бүсэд сайжруулсан ариун цэврийн байгууламжийн эзлэх хувь 30.8-д хүрэв.	100

						Хувийн хэвшлийн 8.5 сая төгрөгийг зарцуулав. (Зураг хавсаргав)	
12	Тогтвортой хөгжлийн боловсрол үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, сургууль, цэцэрлэгийн нэмэгдүүлэх эко тоог	3.0 БХНСАХЗ	Дэмжлэг үзүүлсэн арга хэмжээний тоогоор	Тус хөтөлбөрт 2 сургууль, 1 цэцэрлэг хамрагдаж байна.	“Олон улсын эко сургууль цэцэрлэг хөтөлбөр”-т хамрагдах сургууль, цэцэрлэгийн тоог нэмэгдүүлж, 3-аас доошгүй удаа дэмжлэг үзүүлсэн байна.	“Олон улсын эко сургууль цэцэрлэг хөтөлбөр”-т хамрагдаж байгаа Гурвансайхан сумын ЕБСургууль болон Аймгийн төвийн 1 дүгээр цэцэрлэгийн 2 дахь удаагийн сургалтын төлбөрийн зардлыг байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас гаргав. 1 дүгээр цэцэрлэгийн албан хаагчдад мандлын цэцэг тарих дадлага сургалтыг зохион байгуулж, олон нийтэд сурталчлах видео контент хийж өгөв. Нийт 4 удаа 2.2 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэв.	100
13	“Эко клубийн чуулга уулзалт” зохион байгуулах	5.0 БХНСАХЗ	Хамрагдсан багш сурагчдын тоогоор	2 жилд нэг удаа зохион байгуулдаг бөгөөд 2020 онд 7 эко клубийн 60 сурагч багш нар оролцов.	Аймгийн хэмжээнд зохион байгуулж, 15 сумын сургуулийн 19 эко клубийн нийт 150 гаруй багш, сурагчийг оролцуулсан чуулга уулзалт зохион байгуулсан байна.	Байгальд ээлтэй хандлага, зөв дадал, ногоон худалдан авалт, ногоон амьдралын хэв маягийг төлөвшүүлэх үүднээс эко клубийн 3 дахь удаагийн чуулга уулзалтыг "БҮТЭЭЕ-ХАМГААЛЪЯ" уриан дор 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдөр зохион байгууллаа. Чуулганд 16 эко клубийн 139 сурагч, багш нар оролцлоо. Эко клуб бүр 2-оос дээшгүй хог хаягдал дахин ашиглаж эсвэл хог хаягдал бууруулах, мод арчлах хөнгөвчилсэн хэрэгсэл, байгальд ээлтэй амьдрахыг уриалсан, сурталчилсан уран зураг, гэрэл зураг, хогийн сав гэх мэт бүтээлүүдээр үзэсгэлэн гаргаж, модны тарьц суулгац, үр, тасалгааны цэцэг, мандлын цэцэг, мод цэцэг тарих, арчлахад	100

						<p>шаардлагатай тоног төхөөрөмж, гэрэл зургийн үзэсгэлэнг гаргалаа. Энэхүү үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон, хамгийн сайн эко бүтээгдэхүүн хийсэн 3 эко клубийн үйл ажиллагааг дэмжих үүднээс урамшууллаа.</p> <p>Ойн зурвасын гүйцэтгэлийг хүлээж авахаар Гурвансайхан, Дэлгэрхангай, Сайхан-Овоо сумдад ажиллах үеэр 3 эко клубийн 32 сурагчидтай уулзалт зохион байгуулж, клубийн үйл ажиллагаатай танилцав.</p> <p>Нийт 19 эко клубийн 171 сурагчдыг хамруулав.</p> <p>БХНСАХЗардлаас 5.4 сая төгрөгийг зарцуулав.</p> <p>(Зураг хавсаргав)</p>	
3. Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийг хамгаалах							
14	Агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журмыг шинэчлэн батлах	-	Агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журмыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн байна.	Агаарын тухай хуулийн 15.1 дэх хэсэг	Агаарын чанарыг сайжруулах бүс тогтоож, гэр хорооллын айл өрхийг шөнийн цахилгааны тарифын хөнгөлөлт эдлэх боломжийг бүрдүүлсэн байна.	“Мандалговь хотын агаарын чанарыг сайжруулах бүсэд дагаж мөрдөх журам”-ыг БОАЖЯамны сайд, Дундговь аймгийн Засаг даргын хамтарсан 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн А/427, А/404 тоот хамтарсан тушаал, захирамжаар шинэчлэн батлуулсан бөгөөд Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас хэм хэмжээний актаар бүртгүүлэхээр Хууль зүйн яаманд хүргүүлсэн. Энэхүү журам батлагдсанаар гэр хорооллын айл өрхийг шөнийн цахилгааны тарифын	100

						хөнгөлөлт эдлэх боломж бүрдэж байна.	
15	"Ангилъя-Ариглая-Ашиглая" бүсчилсэн арга хэмжээ зохион байгуулах	9.0 БХНСАХЗ	Ангилсан хог хаягдлын хэмжээ	10 тонн хаягдал тушаасан.	-Удирдамж гарган зохион байгуулна. -Аймгийн хэмжээнд дахивар хаягдлыг 15 тонн-д хүргэнэ.	<p>"Ангилъя-Ариглая-Ашиглая" бүсчилсэн аянг 14 сумын хэмжээнд удирдамж гарган 2022 оны 04 дүгээр сараас 09 дүгээр сарыг дуустал хугацаанд зохион байгуулсан. Мөн Сайнцагаан сумын аж ахуйн нэгж, олон нийтийн бүлгийн дунд хог хаягдал ангилах мини төслийн уралдаан зарлан хог хаягдал ангилах үйл ажиллагаа явуулдаг төвийг шалгаруулан үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллалаа. Аяны хүрээнд Сайнцагаан суманд 8 тн, Сайхан-Овоо суманд 3.5 тн, Дэлгэрцогт суманд 2.5 тн, Луус суманд 3 тн, 4 суманд 3 төрлийн 17 тн дахивар хог хаягдлыг дахивар нөөц авах цэгтээ ангилж цуглуулаад байна.</p> <p>БХНСАХЗардалаас 6.0 сая төгрөгийг зарцуулав.</p> <p>(Зураг хавсаргав)</p>	100
16	Аюултай хог хаягдлыг түр хадгалах агуулахын менежментийг хариуцах байгууллагыг сонгон шалгаруулах	-	Сонгон шалгаруулсан эсэх	Аюултай хог хаягдал түр хадгалах агуулахын газрын зөвшөөрөл олгогдсон.	Менежментийг хариуцах байгууллагыг сонгон шалгаруулсан байна.	Аюултай хог хаягдлыг түр хадгалах агуулахын менежмент хариуцагчийг сонгон шалгаруулахаар тусгай зөвшөөрөл бүхий 8 байгууллагад урилга хүргүүлсэн боловч хариуцагчаар ажиллах санал ирээгүй болно.	0

						(Зураг хавсаргав)	
17	Нутаг дэвсгэрийн хэмжээнд аюултай хог хаягдлын тооллогыг зохион байгуулах	-	Аюултай хог хаягдлын тооллого зохион байгуулсан эсэх	2015 онд хог хаягдлын бүтцийн тооллого зохион байгуулсан.	Аюултай хог хаягдлын тооллого зохион байгуулсан байна.	Нутаг дэвсгэрийн хэмжээнд ЕБСургууль, Эрүүл мэндийн төвүүдийн устгах шаардлагатай химийн бодис болон аюултай хог хаягдлын тооллогыг явуулсан. Тооллогын дүнгээр 31 ААНэгж, байгууллагын 100.98 л шингэн, 3330 кг хатуу химийн бодис, 830 л хаягдал тос, 33ш дугуй, 8.9 кг хэрэглэсэн зүү, тариур оношлуур, 32.4 тн техникийн сод бүртгэгдэв. (Жагсаалтыг хавсаргав)	100
18	Хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах, мөнгөн урамшуулал олгох журам боловсруулж, батлах	-	Засаг даргын захирамж гарсан эсэх	-	Журам батлагдсан байна.	Дундговь аймгийн Засаг даргын 2019 оны А/394 захирамжаар Хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах, мөнгөн урамшуулал олгох журмыг баталсан. 2022 онд 98.3 хувьтай хэрэгжүүлээд байна. (Хэрэгжилтийг хавсаргав)	100
19	Аюултай хог хаягдлыг түр хадгалах агуулахыг барьж дуусгаж, хэвийн үйл ажиллагааг хангах нөхцөлийг бүрдүүлэх	-	Агуулахын барилгыг хүлээж авсан байна.	Аюултай хог хаягдлыг түр хадгалах агуулахын барилгын гүйцэтгэл 70%-тай.	Аюултай хог хаягдлын түр хадгалах агуулахын хэвийн үйл ажиллагаа хангагдсан байна.	Сайнцагаан суманд аюултай хог хаягдлын агуулах байгуулах ажлын тендерт “Бренд шилдэг” ХХК шалгарсан ба агуулахын барилгын ажлыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын даргын А/41 тоот тушаалаар томилогдсон комисс 2022 оны 11 сарын 15-ны өдрийн 28/2022 дугаартай барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлтээр	100

						<p>баталгаажин хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн.</p> <p>Улсын төсвийн 379.8 сая төгрөг зарцуулав.</p> <p>(Зураг хавсаргав)</p>	
20	<p>Аймгийн нутагт дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад байгаль орчинд ээлтэй хэрэглээний соёл хэвшүүлэх, хог хаягдлыг ангилан ялгах дадал зуршлыг төлөвшүүлэх, хүний эрүүл мэнд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар сургалт семинарыг үе шаттайгаар зохион байгуулах</p>	-	<p>-Сургалт зохион байгуулсан тоогоор</p> <p>-Сургалтад хамрагдсан иргэдийн тоогоор</p>	<p>Хог хаягдлын чиглэлээр 57 хүнийг сургалтад хамруулсан.</p>	<p>5 удаагийн сургалт зохион байгуулж, 150-аас доошгүй иргэдийг хамруулна.</p>	<p>Дахивар нөөц авах “Төвшинсайхан төв”-тэй хамтран Сайнцагаан сумын ААНэгж, байгууллагын 69 ажилтан, албан хаагч, Гурвансайхан сумын 52 иргэн, 12 сумын Эко клубын 139 сурагч, Ерөнхий боловсролын 2 сургуулийн 45, Их газрын чулууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 7 албан хаагч, нийт 6 удаагийн сургалтаар 84 ААНэгж, байгууллагын 312 хүнд байгаль орчинд ээлтэй хэрэглээний соёл хэвшүүлэх, хог хаягдлыг ангилан ялгах дадал зуршлыг төлөвшүүлэх, хүний эрүүл мэнд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар сургалт зохион байгуулсан.</p> <p>БХНСАХЗардлаас 0.4 сая төгрөг зарцуулав.</p> <p>(Зураг хавсаргав)</p>	100
21	<p>Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 445 дугаар тушаалаар батлагдсан “Энгийн хог хаягдлын</p>	70.0 ОНТ	<p>Тохижилт хийсэн хогийн цэгийн тоогоор</p>	<p>3 сумын хогийн цэгт тохижилтын ажил хийгдсэн.</p>	<p>3-аас доошгүй сумын төвлөрсөн цэгт тохижилтын ажил хийнэ.</p>	<p>Хог хаягдлын төвлөрсөн цэгийн тохижилтын ажил Хулд суманд 0.2 га, Дэлгэрцогт суманд 0.2 га, Эрдэнэдалай суманд 7 га, Гурвансайхан суманд 10 га, нийт 4 сумын 17.4 га газарт шууж, булшлах ажил хийгдсэн. Орон нутгийн</p>	100

	төвлөрсөн цэг байгуулах, үйл ажиллагаа явуулах, хаах аргачилсан заавар"-ын хэрэгжилтэд хяналт тавих					төсвийн 75.2 сая төгрөгийг зарцуулав. (Зураг хавсаргав)	
22	Аймгийн нутагт дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад байгаль орчинд ээлтэй хэрэглээний соёл хэвшүүлэх, хог хаягдлыг ангилан ялгах дадал зуршлыг төлөвшүүлэх, хүний эрүүл мэнд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар сургалт семинарыг үе шаттайгаар зохион байгуулах	-	-Сургалт зохион байгуулсан тоогоор -Сургалтад хамрагдсан иргэдийн тоогоор	Хог хаягдлын чиглэлээр 57 хүнийг сургалтад хамруулсан.	5 удаагийн сургалт зохион байгуулж, 150-аас доошгүй иргэдийг хамруулна.	Дахивар нөөц авах "Төвшинсайхан төв"-тэй хамтран Сайнцагаан сумын ААНэгж, байгууллагын 69 ажилтан, албан хаагч, Гурвансайхан сумын 52 иргэн, 12 сумын Эко клубын 139 сурагч, Ерөнхий боловсролын 2 сургуулийн 45, Их газрын чулууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 7 албан хаагч, нийт 6 удаагийн сургалтаар 84 ААНэгж, байгууллагын 312 хүнд байгаль орчинд ээлтэй хэрэглээний соёл хэвшүүлэх, хог хаягдлыг ангилан ялгах дадал зуршлыг төлөвшүүлэх, хүний эрүүл мэнд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар сургалт зохион байгуулсан. (Зураг хавсаргав)	100

23	Ашиглалтад өртөн нөөц хомстож буй 1 зүйл ургамлын үрийн жишиг плантаци байгуулах	2.9 БХНСАХЗ	Тарьсан талбайн хэмжээгээр /га/	Өлзийт сумын “Загийн усны хоолой” тусгай хамгаалалттай газраас үрийн нөөцийг түүж бэлтгэсэн.	Сум дундын ойн ангийн мод үржүүлгийн газарт 0.1 га талбайд “Цульхир” ургамлын плантаци байгуулсан байна.	Ховор ургамлын жагсаалтад орсон "Шивүүрт цульхир" / <i>Agriophyllum pungens</i> (Vahl)Link/ ургамлын үрийн жишиг плантаци байгуулах зорилгоор Сум дундын ойн ангийн мод үржүүлгийн газрын 0,1 га талбайд үрээр тарималжуулж, дуслын системээр байнгын усалгааг шийдэв. БХНСАХЗардлаас 2.9 сая төгрөгийг зарцуулав. (Зураг хавсаргав)	100
24	Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах	-	Хамтран ажилласан эсэх	2021 онд урьдчилан сэргийлэх 1 арга хэмжээ авсан.	Тандалт шинжилгээ авахад холбогдох байгууллагатай хамтран ажилласан байна.	Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сумдад тандалт судалгааны ажил зохион байгуулсан. Тандалтаар Хулд, Гурвансайхан суманд тус бүр 1 үнэг галзуу өвчнөөр өвчилсөн байсныг Мал эмнэлгийн газар, Сумын БОХУБайцаагчтай хамтран устгаж халдваргүйжүүлэн, халдвар тархахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсан.	100

25	Зэрлэг амьтдад зориулж, биотехникийн арга хэмжээ авах	2.0 Хувийн хэвшил	Байгуулсан эсэх	Гурвансайхан, Өлзийт сумдад 2 уст цэгийг байгуулсан.	Сайхан-овоо суманд 1 уст цэг байгуулна.	Тус аймгийн 8 сум, улс, орон нутгийн тусгай хамгаалалттай 4 газар, 6 агнуурын бүсэд 511 боодол өвс, 12 тонн хужир, мараа тавьж зэрлэг амьтдад биотехникийн арга хэмжээ авсан. Тусгай хамгаалалттай 8 газарт зэрлэг амьтан ажиглах камер байрлуулж, зэрлэг амьтдын хоол тэжээлийн байдал, хууль бус ан зэргийг хянах боломжтой болов. Мөн Сайхан-Овоо сумын агнуурын бүс гандуу, хуурайшилтай байсан тул зэрлэг амьтдын хорогдлоос сэргийлж шинээр 1 уст цэг, Өлзийт сумын Хөтлийн усанд шинээр 1 уст цэг нийт 2 уст цэг байгуулсан. Орон нутгийн төсөв 20.0 сая.төг, хувийн хэвшлийн 5.0 сая.төг, нийт 25 сая төгрөгийг зарцуулав. (Зураг хавсаргав)	100
26	Уул уурхай болон дэд бүтцийн улмаас эвдэрсэн газрын тооллого зохион байгуулах	10.0 БХНСАХЗ	Тооллогыг 7 суманд зохион байгуулсан байна.	2018 онд Эвдэрсэн газрын тооллогыг зохион байгуулсан.	Хууль бус ашигт малтмал олборлолтын улмаас эвдэрсэн эзэн холбогдогч тодорхойгүй болон бичил уурхайн улмаас эвдэрсэн газруудын тооллогыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулсан байна.	Бичил уул уурхай болон дэд бүтцийн улмаас эвдэрч орхигдсон газрын тооллогыг “Эко Ти Эс Би” ХХК-тай гэрээ байгуулж 6 сумын 13 нэгж талбар бүхий газарт, Гурвансайхан сумын Засаг дарга мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан тус сумын 5 нэгж талбар бүхий газарт, нийт 7 сумын 18 нэгж талбар бүхий газарт тооллогын ажлыг зохион байгуулсан. Тооллогын дүнгээр нийт хууль бус ашигт малтмал олборлолтын улмаас эзэнгүй эвдэрч орхигдсон 91.4 га талбай бүртгэгдсэн. 2018 оны тооллогын дүнтэй харьцуулахад 54.4 га талбай	100

						<p>нөхөн сэргээгдэж буурсан үзүүлэлтэй байна.</p> <p>БХНСАХЗардлаас 10.0 сая төгрөг зарцуулав.</p> <p>(Зураг хавсаргав)</p>	
27	<p>“Нөхөн сэргээлт-2024” нэгдсэн арга хэмжээний аймгийн дэд ажлын хэсгийн үйл ажиллагааг дэмжиж ажиллах</p>	-	<p>Ажлын хэсгийн хэвийн үйл ажиллагаа явуулах санхүүжилтийг шийдвэрлэсэн байна.</p>	<p>Дэд ажлын хэсгийн төлөвлөгөөний биелэлт гарсан.</p>	<p>Ажлын хэсгийн үйл ажиллагааг эрчимжүүлсэн байна.</p>	<p>Нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлэх, эвдэрсэн газрыг бууруулах зорилгоор “Нөхөн сэргээлт-2024” арга хэмжээг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсэг төлөвлөгөөний гүйцэтгэлийн явц, ажил эрчимжүүлэх талаар 2 удаа хуралдаж, хамтарсан хяналт шалгалтын ажлыг 3 удаа зохион байгуулав.</p> <p>2022 оны 14 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг 95.7 хувьтай хэрэгжүүлж орон нутгийн төсвөөс 0.5 сая төгрөг зарцуулав. (Зураг хавсаргав)</p>	100
28	<p>Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж бүрийн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгааллын арга хэмжээг авч хэрэгжүүлэх</p>	-	<p>Нөхөн сэргээсэн талбайн хэмжээ Байгуулсан хөв цөөрмийн тоо Тарьсан модны тоо</p>	<p>10 аж ахуйн нэгж</p>	<p>Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг тусгасан байна.</p>	<p>2022 онд уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулах 12 ААНэгжийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг тусгуулсан. Үүнээс 7 ААНэгж 22600 мод, 2 ААНэгж 11 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 1 аж ахуйн нэгж уст цэгийн тохижилт, цөөрмийн ажлыг тус тус хийж гүйцэтгэв. Хувийн хэвшлийн 51.6 сая</p>	100

						төгрөг зарцуулав. (Зураг хавсаргав)	
29	Эвдэрч, эзэнгүй орхигдсон талбайд нөхөн сэргээлт хийх	-	10-аас доошгүй га талбайд нөхөн сэргээлт хийсэн байна.	-	Нөхөн сэргээлт хийсэн байна.	Уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулдаг 2 аж ахуйн нэгж Өлзийт суманд 1 га, Гурвансайхан суманд 10 га, Сайнцагаан суманд ШТСтанцын үйл ажиллагаа явуулдаг 2 аж ахуйн нэгж 2.2 га, нийт эвдэрч, эзэнгүй орхигдсон 13.2 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийгдсэн. Хувийн хэвшлийн 15.9 сая төгрөг зарцуулав. (Зургийг хавсаргав)	100
4.Усны нөөцийн ашиглах, хамгаалах							
30	Аж ахуйн нэгж, байгууллага, айл өрхийн усны тоолуур суурилуулсан ажлын тоолууржуулалтын хувь хэмжээ, мэдээллийн баталгаат байдалд хяналт тавих	-	Айл өрх, аж ахуйн нэгжийн тоогоор	5 орон сууцанд 105 тоолуур, бусад айл өрхөд 45 нийт 155 ширхэг тоолуур шинээр суурилуулсан. Мэдээллийг 2 удаа хүргүүлсэн.	20-оос доошгүй айл өрх, аж ахуйн нэгжийн тоолууржуулсан мэдээг 2 удаа төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.	2022 онд 5 аж ахуйн нэгж, 75 өрхөд тоолуур суурилуулсан ажлын дүн мэдээг 5, 11 дүгээр сард албан бичгээр Усны газарт хүргүүлэв. (Зураг хавсаргав)	100

31	Булгийн эхийг хашиж хамгаалах, тохижуулах ажлыг зохион байгуулах	15.0 БХНСАХЗ	Хашсан булгийн тоогоор	Гурвансайхан сумын “Баян булаг”, Өлзийт сумын “Рашаант булаг”, Дэлгэрцогт сумын “Эргийн булаг”-ийн эхийг хашиж хамгаалсан.	3 булгийн эхийг хашиж хамгаалсан байна.	Луус сумын “Зодохын булаг”, Хулд сумын “Жирмийн булаг”, Сайхан-Овоо сумын “Жарантайн булаг”-ийн эхийг хашин хамгаалах гэрээг тус сумдын Засаг дарга нартай гэрээ байгуулан гүйцэтгүүлж, газрын даргын А/20 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг актаар хүлээн авлаа. Тус булгуудыг хашиж хамгаалснаар урсац нэмэгдэж 16 өрхийн бог, бод нийлсэн 10655 мал ундаалах боломжийг бүрдүүллээ. БХНСАХЗардлаас 15.0 сая төгрөг зарцуулав. (Зураг хавсаргав)	100
32	Усны сан бүхий газарт тэмдэгжүүлэлтийн ажил зохион байгуулах	4.8 БХНСАХЗ	Тэмдэгжүүлсэн булгийн тоогоор	Дэлгэрцогт, Дэрэн, Цагаандэлгэр, Говь-Угтаал сумдын 22 булгийн эхийг тэмдэгжүүлэв.	30-аас доошгүй булгийн эхийг тэмдэгжүүлсэн байна.	Тус аймгийн хэмжээнд усны нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах, үер, усны гамшгаас сэргийлэх зорилгоор 160 булаг, нуур тойромд 40909,29 га усны сан бүхий газар нутгийг аймгийн ИТХурлын 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 27 дугаар тогтоолоор орон нутгийн тусгай хамгаалалтад авсан. Дэлгэрхангай, Баянжаргалан, Сайнцагаан, сумдын нутагт усны сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүсэд 37 тэмдэг, тэмдэглэгээг байршуулав. БХНСАХЗардлаас 4.7 сая төгрөг зарцуулав. (Зураг хавсаргав)	100

33	Аймгийн төвийн ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолт хязгаарлалтын бүсийг шинэчлэн тогтоож, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх	-	Шинэчлэн батлуулсан эсэх	Сумын ИТХ-ын 2019 оны 10 сарын 21-ний өдрийн 36 тоот тогтоолоор Олгойн говийн эх үүсвэр дээр хориглолт хязгаарлалтын бүс тогтоосон.	Хориглолт, хязгаарлалтын бүсийг шинэчилж батлуулж, Олгойн говийн ус хангамжийн эх үүсвэрт бүсийг шинэчлэн тогтоосон байна.	Сайнцагаан сумын ИТХурлын 2022 оны дугаар тогтоолоор Олгойн говийн ус хангамжийн эх үүсвэрийн хориглолт хязгаарлалтын бүсийг шинэчлэн тогтоосон. (Зураг хавсаргав)	100
5.Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах							
34	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн нэгдсэн өнгө төрх брэндбүүкэд нийцүүлэн байгалийн нөөц газарт хилийн багана байршуулах	6.8 БХНСАХЗ	Байрлуулсан хилийн баганы тоогоор	"Дэлгэрхангай уул" улсын тусгай хамгаалалттай газарт 12 хилийн багана байрлуулсан.	16 хилийн багана байрлуулна.	Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын менежментийг сайжруулах зорилтын хүрээнд "Дэлгэр сервис" ХХК-тай ажил гүйцэтгэх 22/06 тоот гэрээ байгуулж "Загийн усны хоолой" улсын тусгай хамгаалалттай газар нутгийн нэгдсэн өнгө төрх брэндбүүкэд нийцүүлэн 16 эргэлтийн цэгт хилийн багана байрлуулах ажлыг гүйцэтгүүлэв. БХНСАХЗардлаас 6.8 сая төгрөгийг зарцуулав. (Зураг хавсаргав)	100
35	"Бага газрын чулуу" улсын тусгай хамгаалалттай газрын угтах хэсгийг тохижуулах	10.0 БХНСАХЗ, Хувийн хэвшил	Тохижуулалтын ажил хийсэн эсэх	"Бага газрын чулуу" улсын тусгай хамгаалалттай газар мэдээллийн самбар, байгаль хамгаалагчийн байр, эрэгтэй эмэгтэй био 00 зэргийг хийж гүйцэтгэсэн.	Мэдээллийн самбар бүхий 1 угтах хаалга, ангилан ялгах хогийн сав байршуулна.	"Бага газрын чулуу" улсын тусгай хамгаалалттай газарт дотоод, гадаадын жуулчдад зориулсан мэдээллийн самбар бүхий угтах хаалга хийх ажлыг аймгийн "Говийн шуранхай" аялал жуулчлалын холбоотой хамтран хийж гүйцэтгэв. Бага газрын чулуу жуулчны бааз ангилан ялгах хогийн сав байрлуулав. БХНСАХЗардлаас 5.0 сая төгрөг, хувийн хэвшил 1.0 сая төгрөгийг зарцуулав. (Зураг хавсаргав)	100

36	Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах саналыг Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлэх	-	Адаацаг сумын нутагт орших Сүм хөх бүрд орчмын газар нутгийн байгалийн нөөц газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авах шийдвэрийг гаргуулах	Байгаль орчин, аялал жуулчлалын яамны захиалгаар Байгаль орчны судалгаа хөгжлийн төв ТББ-аас 2021 онд үндэслэлийн судалгааг хийж гүйцэтгэсэн. Аймгийн нийт газар нутгийн 5.7%-ийг улсын тусгай хамгаалалтад авсан.	Улсын тусгай хамгаалалтад авах газруудын жагсаалтыг гаргаж, зохих шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн байна.	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 37 дугаар тогтоолоор “Сүм хөх бүрд” аймгийн тусгай хамгаалалттай газрыг ангилал дээшлүүлж 32588.17 га талбайг улсын тусгай хамгаалалтад оруулах саналыг БОАЖЯаманд хүргүүлэв.	100
37	Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд туссан улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөх газруудыг үе шаттайгаар хамгаалалтад авах ажлыг зохион байгуулж, ЗГ-ын 2018 оны 384 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах	-	Улсын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан байршлууд: Цагаан цав-хорхойтын хөндий, модот, Замын сүүжийн хоолой, Зүүн жирмийн нуур, Ширээ уул, Аргийн чулуу, Сүм хөх бүрд	-	Аймгийн Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж хил зааг, байршил хэмжээг мэдээллийн санд бүртгэж, ИТХ-аар батлуулсан байна.	Өлзийт сумын “Дэл уул, Цагаан цав-хорхойтын хөндий, Цагаан суварга” орчмын 336,490,8 га талбайг улсын тусгай хамгаалалтад авахуулхаар сум, аймгийн ИТХурлын 2019 оны тогтоол гаргаж хүргүүлсний дагуу 2022 оны 5 сард Улсын Их Хурлын байгаль орчин, аялал жуулчлалын байнгын хороо, БОАЖЯамны ТХБНУГазрын ажлын хэсэг газар дээр нь ажиллаж нөхцөл байдалтай танилцсан. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 37 дугаар тогтоолоор “Сүм хөх бүрд” аймгийн тусгай хамгаалалттай газрыг ангилал дээшлүүлж 32588.17 га талбайг улсын тусгай хамгаалалтад оруулах саналыг БОАЖЯаманд хүргүүлэв.	100
6.Ойн нөөцийг хамгаалах, “Тэрбум мод” хөдөлгөөнийг өрнүүлж, зорилтын хэрэгжилтийг хангах							
38	Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд	-	Батлуулсан сумын тоогоор	2021 онд 4 сум 10 га газрыг батлуулсан.	1 5 суманд батлуулсан байна.	Аймгийн хэмжээнд ойн зурвас байгуулахаар 750.91 га, мод үржүүлгийн газар байгуулах	100

	ногоон байгууламж байгуулах газрыг батлуулах					зориулалтаар 104.33 га, аймгийн хэмжээнд нийт 855.24 га газрыг 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган батлуулсан.	
39	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах	-	Аймгийн хэмжээнд	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний нээлтийн арга хэмжээ зохион байгуулсан.	2022-2030 оны төлөвлөгөөг гаргаж батлуулж хэрэгжилтийг ханган ажиллана.	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн "Ойн менежментийн мастер төлөвлөгөө-2030"-ыг боловсруулан Аймгийн ИТХурлын 2022 оны 12 сарын 05-ны өдрийн хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад орсон. ИТХурлын 2022 оны дүгээр тогтоолоор батлуулсан. (Зураг хавсаргав)	100
40	Орон нутгийн хөрсөнд дасан зохицсон тарьц, суулгац бэлтгэх мод үржүүлгийн газар шинээр байгуулах	50.0 ОНТ	Шинээр байгуулсан мод үржүүлгийн тоо	Сайнцагаан суманд 5 га газарт мод үржүүлгийн газартай.	2-оос доошгүйг байгуулсан байна.	Хулд суманд "Хөх тэрэм" ХХК 3 га талбайд мод үржүүлгийн газар байгуулж хамгаалалтын зурваст 2800 хайлаас, 300 улиас тарьж, үржүүлгийн зориулалтаар 16,000 улиас мөчрөөр, шар хуайс 200,000, гүйлс 100,000, хайлаас 200,000 үрээр тарин 2024 он гэхэд 500,000 ширхэг тарьц, суулгацыг ногоон байгууламжид гаргахаар төлөвлөн ажиллаж байна. Адаацаг суманд аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Эрдэнэ-Ухаа жуулчны бааз өөрийн эзэмшил газартаа 4 га талбайд мод үржүүлгийн газар байгуулж хүлэмжинд гүйлс, бүйлс, хайлаас, монос, голт бор зэрэг 10000 ширхгийг үрээр, бойжуулах талбайд 150 суулгац, баазын тохижилтод 50 мод, сөөг тарьж ургуулав. Нийт 2 суманд мод үржүүлгийн газар шинээр байгуулагдав. Хувийн хэвшил 80.0 сая төгрөг зарцуулав.	100

						(Зураг хавсаргав)	
41	Мод, сөөгийн үр, мөчрийн нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулах	10.0 ОНТ	Бэлтгэсэн үр, мөчрийн хэмжээгээр	Навчит модны 25 кг үр бэлтгэж стандартын дагуу хадгалж, мөчир 12500 ширхэг үржүүлгийн зориулалтаар тарьсан.	-Навчит модны үр-50 кг -Мөчир 15000-аас доошгүй	Хайлаас 30, бүйлс 6, заг 5, шар хуайс 4, жигд 3, агч 2, голт бор 0,5 кг үр, улаан сухай 7000, улиас 8700, бургасны 3600 мөчрийг тус тус бэлтгэв. Үүнээс 30 кг үр, 19300 мөчрийг шууд тарьж, 25.5 кг үрийг 2023 оны тарилтад бэлтгэн стандартын дагуу хадгалж байна. Нийт навчит модны үр 55.5 кг, мөчир 19300 ширхгийг үржүүлгийн зориулалтаар бэлтгэн тарьц суулгацын нөөц бүрдүүлэв. (Зураг хавсаргав)	100
42	Мод, сөөгийн тарьц, суулгацын нөөц бүрдүүлж, ногоон байгууламжид гаргах ажлыг зохион байгуулах	-	Ургуулсан тарьц, суулгацын тоогоор	12400 ширхэг тарьц, суулгацыг ААН, байгууллага, иргэдэд нийлүүлсэн байна.	15000-аас доошгүй тарьц, суулгац ургуулсан байна.	Сум дундын ойн ангийн Мод үржүүлгийн газраас орон нутгийн хөрсөнд дасан зохицсон 16400, "Байгалиа дээдэлье" ХХК-ны үржүүлсэн 47000, нийт чанарын шаардлага хангасан 63400 ширхэг тарьц суулгацыг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад нийлүүлсэн. (Зураг хавсаргав)	100
43	Ойн зурвас байгуулах	12.5 БХНСАХЗ	Хот суурин газрын ногоон байгууламжийн эзлэх хувиар	Эрдэнэдалай, Цагаандэлгэр, Дэрэн, Говь-Угтаал, Гурвансайхан сум тус бүр 1 га нийт 5 га талбайд ойн зурвас байгуулсан.	5 га талбайд ойн зурвас байгуулж, суурин газрын ногоон байгууламжийн хэмжээг 1%-аар нэмэгдүүлсэн байна.	Сум дундын ойн ангиас Өлзийт суманд 2, Дэлгэрхангай суманд 2, Говь-Угтаал суманд 1, нийт 5 га талбайд ойн зурвас байгуулах ажлыг тус сумдын Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу гүйцэтгүүлж, аймгийн Засаг даргын А/382 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг газар дээр нь актаар хүлээн авлаа. Хот суурин газрын ногоон байгууламжийн эзлэх хувь 1.2 хувиар нэмэгдэж 7.4 хувьд хүрэв.	100

						(Зураг хавсаргав)	
44	Ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд иргэн, хувийн хэвшлийг татан оролцуулж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн хамтарч ажиллах	90.0 Хувийн хэвшил	Модны ургалтын хувь 75%-аас дээш байх	“Мод тарих үндэсний өдөр”-өөр 485 өрх, 246 аж ахуйн нэгж, байгууллагын 3274 иргэн 62670 мод, сөөгийг тарьж цэнэг усалгааг хийлээ. Улсын төсөв 50 сая.төг, орон нутгийн төсөв 15.8 сая.төг, ААНБайгууллага, иргэд 60.2 сая.төг нийт 126.0 сая төгрөгийн хөрөнгөөр гүйцэтгэв	50000-аас доошгүй мод, сөөг тарьсан байна.	“Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийг 2 удаа зохион байгуулж, 1053 өрх, 147 аж ахуйн нэгж, байгууллагын 5690 иргэнийг хамруулан мэргэжил аргазүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Нийт 122884 мод, сөөгийг тарьснаас ургалт 75.8 хувьтай байна. Улсын төсвөөр 90.0, орон нутгийн төсвөөр 122.0, хувийн хэвшлийн хөрөнгөөр 116.3 сая төгрөг зарцуулав. (Зураг хавсаргав)	100
45	Хашиж хамгаалах, тэмдэгжүүлэх ажилд мод ашиглахаас татгалзах, хуванцар болон бусад хог хаягдлыг дахин ашиглах нөхцөлийг бүрдүүлж, худалдан авалтын бодлогоор дэмжих “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтыг	-	Тендерийн ажлын даалгаварт тус асуудлыг тусгасан тоо Хог хаягдлыг дахин боловсруулж хийсэн хашаа, тэмдэгжүүлэлт, шонгийн тоо хэмжээ	-	Хашиж хамгаалах, тэмдэгжүүлэх ажилд мод ашиглахаас татгалзах, хуванцар болон бусад хог хаягдлыг дахин ашигласан байна.	Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт улс, орон нутгийн төсвөөр гүйцэтгэсэн худалдан авах ажиллагааны 3 тендерийн ажлын даалгаварт дахин боловсруулсан бараа бүтээгдэхүүн ашиглах талаар санал тусгуулснаар ойн зурвас байгуулах, булгийн эхийг хашиж хамгаалах ажилд мод ашиглаагүй.	70

	хэрэгжүүлэх арга хэмжээг авах						
46	Мод тарьж ургуулах “1000 сургагч багш” бэлтгэх сургалтад оролцох орон нутгийн оролцогчдын зардлыг шийдвэрлэх, бэлтгэгдсэн сургагч багш нарыг иргэн, аж ахуйн нэгж байгууллагад мод тарьж ургуулах аргыг заах түгээн дэлгэрүүлэх нөхцөл, боломжоор хангах	-	Сургагч багшийн тоо	-	Сум тус бүрээс 3 хүн сургалтад хамрагдсан байна.	БОАЖЯ, БШУЯ, Монгол Улсын Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулиас хамтран зохион байгуулсан мод тарьж ургуулах “1000 сургагч багш” бэлтгэх сургалтад мод үржүүлгийн газарт тарьц үржүүлэх арга технологи, Агро-ойн аж ахуй, Хот суурины ногоон байгууламжийн төлөвлөлт, арчилгаа, хамгаалал сэдвээр 15 сумын 45 иргэнийг цахимаар, “Дундговιο ногооруулья” хөтөлбөрийн хүрээнд мод үржүүлэг, ногоон байгууламж, агропарк байгуулах, хүлэмжийн аж ахуй эрхлэх, мандлын цэцэг тарих 3 удаагийн сургалт 15 сумын 229 иргэнийг танхимаар хамруулж, дадлагажуулав. Нийт 61 сургагч багш бэлтгэгдсэнээр иргэн, аж ахуйн нэгж байгууллагад мод тарьж ургуулах аргыг заах түгээн дэлгэрүүлэх нөхцөл, боломж бүрдлээ. (Зураг хавсаргав)	100
47	Тэр бум мод үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага, жуулчны баазуудтай өөрийн мод үржүүлгийн	-	Мод үржүүлгийн газар байгуулж, тарьц суулгацын нөөц бүрдүүлэн, жуулчдыг мод тарих ажилд		Аялал жуулчлалын баазтай гэрээ байгуулж, арга хэмжээг зохион байгуулсан байна.	“Тэрбум” мод үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөлтийг танилцуулах, өөрийн мод үржүүлгийн газартай байх, тарьц суулгацын нөөц бүрдүүлэх, жуулчдыг мод тарих ажилд хамруулах зорилгоор аймгийн нутаг дэвсгэрт аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 13 жуулчны бааз, амралтын газарт цахим, танхим хосолсон мэдээлэл өгч, танхимаар оролцсон 5 аж ахуйн	100

	газартай байх, тарьц суулгацын нөөц бүрдүүлэх, жуулчдыг мод тарих ажилд хамруулах талаар хамтран ажиллах гэрээ байгуулж, мод тарьж ургуулах ажлыг өргөн хүрээнд зохион байгуулах		хамруулсан байна.			нэгжтэй өөрийн эзэмшил газарт мод үржүүлгийн газар байгуулж, тарьц суулгацын нөөц бүрдүүлэх гэрээ байгуулсан. Адаацаг суманд аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Эрдэнэ-Ухаа жуулчны бааз өөрийн эзэмшил газартаа 4 га талбайд мод үржүүлгийн газар байгуулж хүлэмжинд гүйлс, бүйлс, хайлаас, монос, голт бор зэрэг 10000 ширхгийг үрээр, бойжуулах талбайд 150 суулгац, баазын тохижилтод 50 мод, сөөг тарьж ургуулав. (Зураг хавсаргав)	
7. Аялал жуулчлалыг хөгжүүлэх							
48	Аялал жуулчлалын нэгдсэн бодлого менежментийн төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, батлуулах	100.0 ОНТ	Мастер төлөвлөгөө батлуулсан эсэх	2012-2018 онд мастер төлөвлөгөө батлуулан ажилласан.	Мэргэжлийн байгууллагатай гэрээ хийж, боловсруулан батлуулсан байна.	Барилга, хот байгуулалтын яамны санхүүжилтээр “Цагаан суварга” байгалийн үзэсгэлэнт газрыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг “Нарт дизайн” ХХК боловсруулж байна. Төлөвлөгөөний дагуу суурь судалгааны ажил хийгдэж дуусган, төлөвлөлтийн ажил хийгдэж байна. Улсын төсвийн 269.0 сая төгрөгөөр гэрээ байгуулсан. (Зураг хавсаргав)	70
